



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/67

Халбан

**Согтууруулах ундаа худалдан борлуулахыг
түр хугацаагаар хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн A/260 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн 2024 онд “Хүүхэд хөгжил, хамгааллыг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүүхдийн эрх зөрчигдөх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр сумын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Энэ өдөр архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг иргэн, аж ахуйн нэгжийн захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж хяналт, шалгалтыг зохион байгуулж ажиллахыг Цэцэрлэг сумын Хэсгийн төлөөлөгч (Ахлах дэслэгч Д.Нямдорж)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д даалгасугай.

ДАРГА



Н.АНХБАЯР